ЗӨВШӨӨРСӨН:
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ц. ЭРДЭМБИЛЭГ

БАТЛАВ:
СЭТГЭЦ СУДЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА В.БАЯРМАА

# ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН **“СЭТГЭЦ СУДЛАЛ”** ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

**ИНДЕКС**: S(r) 091214

**ХУГАЦАА**: 2 жил

**УЛААНБААТАР ХОТ**

**2022 ОН**

**БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ:**

| | |
|---|---|
| Д.Оюунсүрэн | Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сэтгэц судлалын тэнхимийн ахлах багш, сэтгэц судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Анагаах ухааны доктор, Тэргүүлэх зэргийн эмч |
| В.Баярмаа | Сэтгэц судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн дарга, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал, Анагаах ухааны доктор, Тэргүүлэх зэргийн эмч |
| Н.Алтанзул | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч, Монголын Сэтгэцийн эрүүл мэндийн нийгэмлэгийн нарийн бичгийн дарга, Анагаах ухааны доктор |

**ХАМТРАН АЖИЛЛАСАН**

**Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн төлөөлөл:**

| | |
|---|---|
| З.Хишигсүрэн | Сэтгэц судлалын тэнхмийн эрхлэгч, сэтгэц судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Анагаах ухааны доктор, профессор, сэтгэцийн зөвлөх зэргийн эмч |

**ХЯНАСАН**:

| | |
|---|---|
| П.Эрхэмбаяр | Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Нийгмийн эрүүл мэндийн магистр; |
| Б.Туяа | Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Салбарын хүний нөөцийн мэргэшил, сургалт, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн; |
| Д.Дондогмаа | Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны ахлах мэргэжилтэн, Анагаах ухааны магистр; |

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2022 оны 9 дугаар сарын 09-ний өдрийн
16 дугаар тогтоолоор зөвшөөрөв.

# ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН "СЭТГЭЦ СУДЛАЛ" ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

## НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Дэлхийн Эрүүл Мэндийн Ассамблейгаас 2013 онд баталсан ДЭМБ-ын Сэтгэцийн эрүүл мэндийн 2013-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд бүх нийтийн эрүүл мэндийг хангахад сэтгэцийн эрүүл мэнд чухал үүрэг гүйцэтгэхийг онцлон тэмдэглэсэн байдаг. Энэхүү төлөвлөгөөнд дараах 4 үндсэн зорилт багтсан. Тухайлбал:

- Сэтгэцийн эрүүл мэнд дэх манлайлал, засаглалыг илүү үр дүнтэй болгох
- Олон нийтэд түшиглэсэн орчинд сэтгэцийн эрүүл мэнд, нийгмийн халамжийн цогц үйлчилгээг үзүүлэх;
- Сурталчлах, урьдчилан сэргийлэх стратеги бодлогын хэрэгжилтийг сайжруулах
- Мэдээллийн систем, нотлох баримт, судалгааг бэхжүүлэх зэрэг юм.

ДЭМБ-ын баримтлаж буй бодлого, чиглэлийн дагуу манай улс нь сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үндсэн буюу төрөлжсөн шатлалын тусламжаас нийгэм хамт олон, өрхийн эмнэлэгт суурилсан тусламж үйлчилгээ рүү чиглэсэн тусламж үйлчилгээнд шилжүүлэх анхны алхмыг 2015 оноос хэрэгжүүлж эхэлсэн нь сэтгэцийн эмгэг судлалын резидентийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах хэрэгцээ үүсээд байгаа юм.

Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 сарын 10-ны өдрийн А/774 тоот тушаалын хэрэгжилтийг ханган, ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2019 оны 06 сарын 03-ны өдрийн хурлын №01 тоот тогтоолд дурьдсан ёсоор "Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөр"-ийг шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

Иймд бид энэхүү сургалтын хөтөлбөрт өөрийн орны болон олон улсын стандартад нийцүүлсэн, дэлхийн орчин үеийн чиг хандлагад тохирсон сургалтын хөтөлбөрийг боловсруулж сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд сэтгэцийн тусламж, үйлчилгээг олон талт, цогц, уян хатан байдлаар үзүүлэх чадвартай сэтгэцийн эмч бэлтгэх, бусад мэргэжлийн эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд зөвлөх чадвар бүхий мэргэжилтэнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, эмнэлзүйн дадал зүйг тусгасан болно.

Энэхүү сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын Үндсэн Хууль, Дээд боловсролын тухай хууль болон бусад холбогдох хууль дүрэм журмыг үндэслэн ахисан түвшний боловсролын үйл ажиллагаа болох төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын дагуу боловсруулсан болно.

## ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО

Сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэцийн эмгэг судлалаар онолын болон эмнэлзүйн өндөр мэдлэгтэй, сэтгэцийн эмгэгүүдийн оношилгоо, эмчилгээний стандарт болон эмнэлзүйн удирдамжид нийцүүлсэн, бүх шатлалын тусламж үйлчилгээний түвшинд олон улсын хэмжээнд дүйцэхүйц сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бие даан үзүүлэх ур чадвар эзэмшсэн сэтгэцийн эмч бэлтгэхэд оршино.

## ГУРАВ. АЛСЫН ХАРАА

**“Сэтгэц судлал” үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрөөр бэлтгэх эмчийн дүр зураг:**

Төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн Сэтгэцийн эмгэг судлалын мэргэжил эзэмшигч нь мэргэжилтний цогц чадамж (BluePrint)-д тусгагдсан үндсэн 6 үүрэг болох **ХАРИЛЦАГЧ, ХАМТРАГЧ, ЗОХИОН БАЙГУУЛАГЧ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗӨВЛӨГЧ, ТАСРАЛТГҮЙ СУРАЛЦАГЧ, МЭРГЭЖИЛТЭН**-ий чадварыг хослуулан, үйлчлүүлэгч эмчлүүлэгч төвт сэтгэцийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг мэдлэгийн K2, эмнэлзүйн ур чадварын S2, мэргэжлийн ёсзүй, хандлагын A2 түвшинд үзүүлэх ахисан түвшний боловсрол эзэмшиж төлөвшсөн мэргэжилдээ мэргэшсэн цогц чадамжтай байх болно.

## ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН “СЭТГЭЦИЙН ЭМЧ”-ИЙН ЦӨМ ЧАДАМЖ

Алсын харааг биелүүлэхэд чиглэсэн дараах цөм чадамжтай байна:

1. Сэтгэцийн эмч (Psychiatrist)
2. Мэргэжилтэн байх (Professional)
3. Тасралтгүй суралцагч (Learner)
4. Харилцагч (Communicator)
5. Хамтрагч (Collaborator)
6. Эрүүл мэндийн зөвлөгч (Health advocator)
7. Зохион байгуулагч (Manager)

## ТАВ. СУРГАЛТЫН ЗОРИЛТ

Цөм чадамж бүхий сэтгэцийн эмч болохын тулд дараах дэд чадамжийг эзэмшиж, бие даан гүйцэтгэж чаддаг болно. Үүнд:

**1. Сэтгэцийн эмч (Psychiatrist):**

- Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалахад хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллага, шийдвэр гаргагч нарыг чиглүүлэх, сургах, удирдах, зохион байгуулах;
- Хүн амын дунд зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн шинж тэмдгийг (signs and symptoms) таньж ялган оношлох, анхан, үндсэн, төрөлжсөн шатны тусламж үйлчилгээг үзүүлэх;

- Үйлчлүүлэгч, түүний гэр бүл, асран халамжлагч болон бусад эх сурвалжаас үнэн зөв, товч тодорхой чухал хамааралтай мэдээллийг асууж цуглуулан, одоогийн сэтгэцийн байдлыг тодорхойлох, үйлчлүүлэгчийн нийгэм-сэтгэлзүйн нөхцөл байдлыг үнэлж оношилгоо, эмчилгээ, хяналтын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;
- Анхан, үндсэн, төрөлжсөн сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нөөц бололцоонд тулгуурлан, үйлчлүүлэгчид үзүүлэх яаралтай болон бусад тусламж үйлчилгээг зохистой шийдвэрлэх;
- Сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагын бүртгэл болон тайлангийн маягтыг зохих журмын дагуу цаг хугацаанд нь хөтлөх;
- Аюулгүй жор бичих, жортой холбоотой гарч болох алдаанаас сэрэмжлэх, оношилгоо эмчилгээний сонголттой холбоо бүхий мэдээллийг олж авах, эмнэлзүйн үйл ажиллагаандаа ашиглах;
- Үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийн хувийн нууцыг чандлан хадгалан, аюулгүй байдлыг хангах, эмнэлэг хамгаалал, халдвар хамгааллын дэглэмийг сахих;
- Үйлчлүүлэгч болон түүний гэр бүлд тулгарч буй сэтгэцийн эмгэгтэй холбоотой асуудалд анхаарал хандуулах, эмчлүүлэгчийн нийгмийн эрүүл мэндийг дэмжих;
- Анагаах ухааны холбогдох мэдээ, мэдээллийн менежментийг ашиглах;

**2. Мэргэжилтэн байх (Professionalism):**

- Тусламж үйлчилгээг чанарын өндөр түвшинд үзүүлэх, мэргэжилтэн хоорондын харилцаанд тохиромжтой зан төлөвийг баримтлаж ажиллах;
- Анхан, үндсэн, төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлдэг салбаруудад өөрийн мэргэшлээр хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзэлтэй байх;
- Өдөр тутмын ажилдаа анагаах ухаан, хууль зүй, мэргэжлийн хэм хэмжээг хүндэтгэн, ёс зүйн хариуцлагаа ухамсарлан ажиллах;
- Үйлчлүүлэгчийг хувь хүний хувьд хүндэтгэж, хамгийн оновчтой зөв шийдвэр гаргахын төлөө ажиллах;
- Хувь хүний онцлогийг харгалзан үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийн гишүүн, асран халамжлагч, төрөл садны хүнтэй хүндэтгэлтэй харилцах;

**3. Тасралтгүй суралцагч (Learner):**

- Тасралтгүй сургалтын хувийн төлөвлөгөөгөө боловсруулан хэрэгжүүлэх, баримтжуулах;
- Анагаах ухааны чиглэлээр тулгарч буй асуудалд шинжлэх ухаанчаар шүүмжлэлтэй хандах, эмнэлзүйн шийдвэр гаргалтанд шинжлэх ухааны нотолгоог ашиглах;
- Өдөр тутам шинэчлэгдэж байгаа анагаах ухааны дэвшлээс хоцрохгүйн тулд бие даан тасралтгүйгээр суралцах, олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг судлах, дүн шинжилгээ хийх;

- Хамтран суралцагч эмч, бусад эмнэлгийн мэргэжилтний сурах үйл ажиллагааг дэмжих;
- Шинэ мэдлэг бий болгох, түгээх, ашиглах;

4. **Харилцагч (Communicator):**

- Үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийн гишүүн, асран халамжлагч, төрөл, садны хүнд шаардлагатай мэдээлэл өгөх, итгэл төрүүлэх, ёс зүйтэй эмнэлзүйн харилцаа үүсгэх;
- Үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийн гишүүн, асран халамжлагч, хамт олон, бусад мэргэжлийн хүмүүст холбогдох мэдээлэл, тайлбарыг танилцуулж, цаашид авах арга хэмжээний талаар санал солилцон, төлөвлөгөө боловсруулах;
- Шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчийн оношилгоо, эмчилгээний талаар бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй зөвлөлдөх;
- Эмчлүүлэгч, үйлчлүүлэгчийн талаархи мэдээллийг бичгээр болон амаар үнэн зөв дамжуулах;

5. **Хамтрагч (Collaborator):**

- Үйлчлүүлэгч, эмчлүүлэгчид чанартай, аюулгүй тусламж үйлчилгээ үзүүлэх зорилгоор удирдлага, эрүүл мэндийн бусад мэргэжилтнүүдтэй зөвшилцөн багаар хамтран ажиллах;
- Бусад эмнэлгийн эмч, эрүүл мэндийн мэргэжилтэнтэй мэргэжлийн мэдлэг, мэдээллээ хуваалцаж, салбар дундын багийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцох;

6. **Эрүүл мэндийн зөвлөгч (Health Advocator):**

- Нийт хүн амын болон хувь хүний эрүүл мэндийг сахин хамгаалахад чиглэсэн хүчин чармайлт гарган, тусламж үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа явуулах;
- Сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж зөвлөгөө өгөх
- Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

7. **Зохион байгуулагч (Manager):**

- Өөрийн сургалтын хэрэгцээ, хувийн амьдрал, эрүүл мэндийн байдалдаа цаг хугацаа боломжит нөөцийг үр дүнтэйгээр ашиглах;
- Үйлчлүүлэгч эмчлүүлэгчийн нэн тэргүүнйи хэрэгцээнд үндэслэн эрүүл мэндийн тусламжийн хязгаарлагдмал нөөц бололцоогоо ахмад эмчийн0 хяналтан дор ашиглах;
- Эрүүл мэндийн байгууллагад бүтээлчээр үр ашигтай ажиллах;
- Үйлчлүүлэгч, эмчлүүлэгчийн аюулгүй байдлыг ханган, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохицуулах, манлайлан ажиллах үүргээ ухамсарлах;

- Эмнэлэг, эрүүл мэндийн төв дэх тусламж үйлчилгээ үзүүлэх багийг манлайлан ажиллах үүргээ ухамсарлах;

## ЗУРГАА. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

### 6.1. Сургалтын чиглэл, хугацаа, байршил

- Сэтгэц судлал үндсэн мэргэшлийн сургалтаар 11 чиглэлээр тойролт заавал хийж, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний сургалт болон сонгон суралцах чиглэлээр сургалтанд хамрагдана.
- Сургалтын нийт хугацаа 2 жил байна.
- Сургалт эрхлэх байгууллага дээр зохион байгуулагдаж буй Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлага, мэргэжлийн үнэ цэнэ, Халдварын сэргийлэлт, хяналт, Амилуулах суурь тусламж, Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль, журам, зөрчлийн тухай хууль, хувь хүний нууцтай холбоотой хууль, Эмнэлгийн эрх зүйн чиглэлээр сургалтанд заавал хамрагдана.
- Сонгон суралцах чиглэлийг Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв болон Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль зөвшилцөн гаргана.
- Суралцагч эмчийн өдөр тутмын болон 7 хоногийн үйл ажиллагааны тодорхой хуваарийг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн сургалтын алба болон Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс зөвшилцөн боловсруулна.
- Сургалт явуулах үндсэн байгууллага нь Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль байна.
- Геронтологийн үндэсний төв, Нийслэлийн яаралтай тусламжийн төв, Монгол Японы эмнэлгийн мэдрэлийн тасаг, Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн хэл заслын кабинет, (Нийслэлийн Хүүхдийн сэргээн засах төв), Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Наркологийн эмнэлэг, дүүргүүдийн эрүүл мэндийн төв зэрэг байгууллагатай сургалт эрхлэх байгууллагын сүлжээ үүсгэн хамтран ажиллана.
- Сургалтын онолын суурь мэдлэг олгох лекцийг тухайн салбарын тэргүүлэх зэргийн эрдэмтэн судлаач багш, эмч нар хуваарийн дагуу уншина.

### 6.2 Зайлшгүй танин мэдэж, суралцах шаардлагатай шинж тэмдэг, өвчин, гардан үйлдэл:

Сургалтын төгсгөлд бие даан сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр анхан, үндсэн, төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлж чадах түвшинд хүрэхийн тулд эмнэлзүйн сургагч багшийн хяналтан дор амбулаториор ирэх үйлчлүүлэгч болон хэвтэн эмчлүүлэх үйлчлүүлэгчийн оношилгоо, эмчилгээг хариуцан хийх явцдаа дараах үндсэн мэдлэг, шинж тэмдэг, өвчин, гардан үйлдлийг гүйцэтгэж, туршлага хуримтлуулна.

#### 6.2.1 Шинж тэмдэг (signs and symptoms):

Өвчний түүх, одоогийн сэтгэцийн байдал, бодит үзлэгт үндэслэн эрэмблэн ангилж, ялган оношилгоо хийн, анхан шатны эмчилгээг эхлүүлж чаддаг болох:

1. Мэдэрч танин мэдэхүйн өөрчлөлтүүд /Disorders of perception/
2. Сэтгэхүйн өөрчлөлтүүд /Disorders of thinking/

3. Ой тогтоолтын өөрчлөлтүүд /Disorders of memory/
4. Анхааралын өөрчлөлтүүд /Disorders of attention and concentration/
5. Оюун ухааны өөрчлөлтүүд /Disorders of intellect/
6. Сэтгэл хөдлөлийн өөрчлөлтүүд /Disorders of emotions/
7. Зориг үйлдэл ба дурын өөрчлөлтүүд /Disorders of motor and will/
8. Ухамсарт ухааны өөрчлөлтүүд /Disorders of consciousness/
9. Негатив шинжүүд /Negative symptoms/
10. Позитив шинжүүд /Positive symptoms/

Сэтгэцийн эмгэгийн зарим хам шинжүүд

1. Сэтгэц эмгэгийн хам шинж, өвчин тэдгээрийн харилцан хамаарал
2. Сульдлын хам шинж
3. Истерийн хам шинж
4. Эмгэг төрхийн хам шинж
5. Кандиский-Клерамбогийн хам шинж
6. Бардамнах дэмийрлийн хам шинж
7. Капграгийн хам шинж, Котарын хам шинж
8. Кататоник хам шинж
9. Эмгэг төрх төст хам шинж
10. Хүүхдэрхэх хам шинж, уналт таталтын хам шинж
11. Хараат байдлын хам шинж
12. Нейролептик хам шинж
13. Ойгүйдлийн хам шинж
14. Сэтгэц органик хам шинж
15. Сэтгэл хөөрлийн хам шинж
16. Сэтгэл гутралын хам шинж
17. Сэтгэлгүйдлийн хам шинж
18. Ухаан дэмийрэн балартах хам шинж
19. Ухаан зүүдчилэн балартах хам шинж
20. Ухаан будангуйран балартах хам шинж
21. Ухаан бүрийтэн балартах хам шинж
22. Ухаан нойрмоглон балартах хам шинж

**6.2.2. Ерөнхий сэтгэцийн эмгэг судлал (General psychiatry Z13.39):**

1. Сэтгэцийн эмгэг тус бүрийг оношилж, эмчлэх, тусламж үзүүлж чаддаг болох
2. Зонхилон тохиолдох сэтгэц эмгэгийн шинж тэмдгүүд, хамшинжүүдийг илрүүлэн үнэлж зохих тусламжийг төлөвлөхөд суралцах
3. Тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад анхан шатны эмнэлгээс үндсэн, төрөлжсөн шатны эмнэлэгт үйлчлүүлэгч шилжүүлэх заалтыг мэддэг болох
4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний онцлогоос шалтгаалан бусад эрүүл мэндийн төвүүдэд үйлчлүүлэгчийг аюулгүйгээр шилжүүлэхэд суралцах
5. Үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнд эмгэгээс урьдчилан сэргийлэх, эмгэгийг эрт үед нь илрүүлэх талаар зааж, зөвлөгөө өгөхөд суралцах

**Донтолт судлал (Addiction medicine F1)**

1. Мансууруулах бодисууд, тэдгээрийн ангилал ба олон улсын хяналтын тогтолцоо
2. Сэтгэц идэвхит бодисын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүдийн шалтгаан, ангилал ба тархалт (F1 Mental and behavioral disorders due to use of psychoactive substance)
3. Сэтгэц идэвхит бодисын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүдийн эмнэл зүйн ерөнхий шинжүүд
4. Архины шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд, архинаас гаргах, Миннесота загварын эмчилгээ (F10 Mental and behavioral disorders due to use of alcohol)
5. Опиодуудын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд (F11 Mental and behavioral disorders due to use of opioids)
6. Каннабиноидын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд (F12 Mental and behavioral disorders due to use of cannabinoids)
7. Тайвшруулах буюу унтуулах бодисын шалгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд (F13 Mental and behavioral disorders due to use of sedatives or hypnotics)
8. Кокаины шалтгаант зан үйлийн болон сэтгэцийн эмгэгүүд (F14 Mental and behavioral disorders due to use of cocaine)
9. Сэтгэл сэргээгч эм бодисын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд (F15 Mental and behavioral disorders due to use of stimulants, including caffeine)
10. Хий үзэгдэл үүсгэгч бодисын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд (F16 Mental and behavioral disorders due to use of hallucinogens)
11. Тамхины шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд (F17 Mental and behavioral disorders due to use of tobacco)
12. Дэгдэмхий уусагч бодисын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд (F18 Mental and behavioral disorders due to use of volatile solvents)
13. Хүн амд үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шатлал
14. Анхан, үндсэн, төрөлжсөн шатлалын тусламж үйлчилгээний онцлог

**Хүүхэд, өсвөр үеийн сэтгэцийн эмгэг судлал (Child and adolescent psychiatry F8-F9)**

1. Хүний амьдралын мөчлөгийн тухай биологи, нийгэм сэтгэл зүйн онцлог, сэтгэцийн онтогенез ба дезонтогенез хөгжлийн асуудлууд
2. Сэтгэц бэлгийн хөгжлийн үе шатны тухай үзэл баримтлалууд, Хүүхэд хамгаалал, Хүүхдийн сэтгэл зүйн гэмтэл
3. Хүүхэд насанд голчлон тохиолдох сэтгэцийн эмгэгийн шинж, хам шинжүүд тэдгээрийн оношийн ач холбогдол (F80-F89 Disorders of psychological development)
4. Өсвөр насныханд голчлон тохиолдох сэтгэцийн эмгэгийн шинж, хам шинжүүд тэдгээрийн оношийн ач холбогдол (F90-F98 Behavioral and emotional disorders with onset usually occurring in childhood and adolescence)
5. Хүүхэд өсвөр насныханд тохиолдох гадаад шалтгаант сэтгэцийн эмгэгүүдийн /халдвар, хордлого, гэмтэл/ онцлог өсвөр насныхны архинд донтох өвчин, хорын дон, мансуурах донгийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйс, эмгэг жам, ангилал, шинж тэмдэг, өвөрмөц эмчилгээний зарчим, зөвлөгөө, мэдээлэл өгөх тухай ойлголт

6. Хүүхэд өсвөр насныханд тохиолдох дотоод шалтгаант сэтгэцийн эмгэгүүд /шизофрени, үечилсэн солиорол, эпилепси/- ийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйс, эмгэг жам, ангилал, шинж тэмдэг, өвөрмөц эмчилгээний зарчим, зөвлөгөө, мэдээлэл өгөх тухай ойлголт
7. Хүүхэд өсвөр насныханд тохиолдох сэтгэлийн шалтгаант сэтгэцийн эмгэгүүд /невроз, сэтгэлийн шалтгаант солиорол/-ийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйс, эмгэг жам, ангилал, шинж тэмдэг, өвөрмөц эмчилгээний зарчим, зөвлөгөө, мэдээлэл өгөх тухай ойлголт
8. Хүүхэд өсвөр насныханд тохиолдох эмгэг төрх, төрх үйлийн эмгэгийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйс, эмгэг жам, ангилал, шинж тэмдэг, өвөрмөц эмчилгээний зарчим, зөвлөгөө, мэдээлэл өгөх тухай ойлголт (F90-F98 Behavioral and emotional disorders with onset usually occurring in childhood and adolescence)
9. Оюуны хомсдол өвчний үүсэх шалтгаан, эмнэл зүйн онцлогууд. Оюуны хомсдол төст хам шинжүүдийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйс, эмгэг жам, ангилал, шинж тэмдэг, өвөрмөц эмчилгээний зарчим, зөвлөгөө, мэдээлэл өгөх тухай ойлголт (F70-F79 Mental retardation)
10. Цахимд донтох шалтгаан, эмнэл зүйн онцлог, ялгах онош, эмчилгээ (F63.0 Pathological gambling; Y93.C2 Activity, hand held interactive electronic device)
11. Дисморфофоби, Дисморфомания өвчний үүсэх шалтгаан, эмнэл зүйн онцлогуудын шалтгаан, нөлөөлөх хүчин зүйс, эмгэг жам, ангилал, шинж тэмдэг, өвөрмөц эмчилгээний зарчим, зөвлөгөө, мэдээлэл өгөх тухай ойлголт (F45.22 Body dysmorphic disorder)
12. Хүүхэд өсвөр насныхны амиа хорлох, амиа хорлох оролдлого хийх шалтгаан, нөлөөлөх хүчин зүйс, эмгэг жам, ангилал, шинж тэмдэг, өвөрмөц эмчилгээний зарчим, зөвлөгөө, мэдээлэл өгөх тухай ойлголт
13. Орондоо шээх эмгэг өвчний үүсэх шалтгаан, эмнэл зүйн онцлогууд, ялгах онош, эмчилгээ (F98.0 Nonorganic enuresis)
14. Булчин татгавнах (ТИК) өвчний үүсэх шалтгаан, эмнэл зүйн онцлог, ялгах онош, эмчилгээ (F95.9 Tic disorders)

**Шүүхийн сэтгэцийн эмгэг судлал (Forensic psychiatry Z04.6)**

1. Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын тухай ойлголт, түүний судлах зүйл
2. Монголд шүүхийн сэтгэцийн эмгэг судлал хөгжсөн түүх
3. Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын магадлагааны хэлбэрүүд , хэрэг хариуцах чадваргүй байдлын тухай ойлголт
4. Хэрэг хариуцах чадвартай эсэхийг тогтоох шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын магадлагаа, ялтан, хохирогч нарт хийх шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын магадлагаа
5. Нийгэмд аюултай үйлдэл хийсэн сэтгэцийн өвчтөнд хэрэглэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, иргэний хэрэгтэй холбогдолтой шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын магадлан шинжилгээ
6. Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын магадлагаа хийх эрх зүйн үндэслэлүүд
7. Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын магадлагаанд сэтгэл судлалын аргыг хэрэглэх нь
8. Сэтгэцийн өвчин тус бүрийн үед өгөх шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын магадлагааны үнэлэлтүүд
9. Онцгой байдлууд хэмээх сэтгэл түр сарнисан үед өгөх шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын магадлагааны үнэлэлт

10. Сэтгэцийн өвчний баашлалт (F54; Z76.5 Psychological and behavioral factors associated with disorders or diseases classified elsewhere)
11. Насанд хүрээгүй хүмүүсийн шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын магадлагааны онцлог, эрх зүйн чадамжийн тухай

***F4, F6 Сэтгэлийн шалтгаант болон бие хүний эмгэг ба бэлгийн эмгэг судлал (Stress-related, and personality disorders and sexual pathology)***

1. Стрессийн тухай ойлголт, стрессийн шинж тэмдэг, стресс менежмент
2. F4. Стресстэй холбоотой үүсэх неврозын ба биеийн хэлбэрийн эмгэгүүд (Айдсын эмгэгүүд F40 Phobic anxiety disorders; Сэтгэл түгших эмгэг F41 Other anxiety disorders; Сандрах эмгэг F41.0 Panic disorder; Улигт бодол-албадмал үйлдлийн эмгэг F42 Obsessive-compulsive disorder; Стрессийн дараах цочмог хариу урвал F43 Reaction to severe stress, and adjustment disorders; Диссоциатив эмгэгүүд F44 Dissociative disorders; Биеийн хэлбэрийн эмгэг F45 Somatoform disorders; Архаг ядаргаа F48 Other neurotic disorders)- ийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйс, эмгэг жам, ангилал, шинж тэмдэг, өвөрмөц эмчилгээний зарчим, зөвлөлгөө, мэдээллийн тухай ойлголт
3. Сэтгэц бэлгийн хөгжлийн үе шатны тухай Фрейд, Эриксон нарын онол
4. Бэлгийн амьдралын тухай ойлголт, Бэлгийн харилцааны зан үйл, бэлгийн мэдрэмж,
5. Хүйсээ ухамсарлах ухамсар бүрэлдэн тогтох үе /1-7нас/, Хүйсэндээ тохирсон зан үйл бүрэлдэн тогтох үе шат /7-13нас/, Сэтгэц бэлгийн чиг баримжаа тогтох үе шат /13-18нас/
6. Бэлгийн хөгжил ба чиг баримжаатай холбоотой сэтгэл зүйн ба зан үйлийн эмгэгүүд, Гетеросекс, гомосекс, бисекс хэв маягууд, Биологийн нөлөө, удамшлын нөлөө, нийгмийн сөрөг үзэгдлийн нөлөө, буруу хүмүүжлийн нөлөө гэх мэт ойлголтууд (F66 Psychological and behavioral disorders associated with sexual development and orientation)
7. Бэлгийн бойжилтын эмгэг, хүйсээ өөрчлөх эмгэг, бэлгийн харилцааны эмгэг, хүйсээ ижилсүүлэх эмгэг, трансексуализм, хоёрдмол үүргийн трансексуализм, хүүхдийн хүйсээ шилжүүлэх эмгэг гэх мэт ойлголтууд (F64 Gender identify disorders)
8. Насанд хүрэгчдийн бие хүний ба төрх үйлийн эмгэг (Бие хүний өвөрмөц эмгэгүүд F60 Specific personality disorders; Бие хүний холимог эмгэгүүд F61 Mixed and other personality disorders; Бие хүний завсрын эмгэгүүд F62 Enduring personality changes, not attributable to brain damage and disease, Зуршилт ба импульсив эмгэгүүд F63 Habit and impulse disorders)- ийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйс, эмгэг жам, ангилал, шинж тэмдэг, өвөрмөц эмчилгээний зарчим, зөвлөлгөө, мэдээлэл өгөх тухай ойлголт

***Сэтгэцийн өвчний үеийн яаралтай тусламж (Emergency care in mental disorders R41.82)***

1. Нийгэмд аюултай үйлдэл хийх эрсдэл бүхий сэтгэцийн өвчтэй хүмүүст үзүүлэх яаралтай тусламж (Altered mental status R41.82 or 780.97)
2. Сэтгэц хөдөлгөөний дошгирол бүхий сэтгэцийн өвчтэй хүмүүст үзүүлэх яаралтай тусламж (Altered mental status R41.82; 780.97)

3. Эпилепсийн статусын үед үзүүлэх тусламж (Epilepsy, with status epilepticus G40.901; 345.90)
4. Ухаан балартал ба ухаан алдсан өвчтөнд үзүүлэх тусламж (Delirium due to known physiological condition F05, 293.0)
5. Нийгэмд аюултай үйлдэл хийх эрсдэлтэй өвчтөнүүдийн бие-сэтгэцийн байдлыг үнэлэх, оношлох, дошгиролтой өвчтөнд үзүүлэх түргэн тусламж, номхотгох аргыг хэрэглэх, ЭМС-ын 180 тоот тушаал
6. Хоол унднаас татгалзсан (Refuse from food F50.89), хөшилтэй (Catatonic schizophrenia F20.2; Organic catatonia F06.2) өвчтөнд үзүүлэх түргэн тусламж

**Сэтгэц нөлөөт эм судлал (Psychopharmacology Z79)**

1. Сэтгэл нөлөөт эмийн тухай ойлголт, ангилал, төрөл, эмчилгээг хийх заалт, эсрэг заалт, жор бичих мэдлэг
2. Эмчилгээний үндсэн зарчмууд, биеийн ерөнхий эсэргүүцлийг сайжруулах эмчилгээ
3. Хордлого тайлах эмчилгээ, органик өөрчлөлтийг шимэгдүүлэх эмчилгээ,
4. Халуурах эмчилгээ, цахилгаанаар таталдуулах эмчилгээ (ЭСТ, Пирогенал)
5. Нейролептик эмийн эмчилгээ (Neuroleptic treatment G21.0; 333.92)
6. Сэтгэлийн хөдөлгөөн тогтворжуулах эмийн эмчилгээ
7. Тайвшруулах эмийн эмчилгээ
8. Сэтгэл гутралын эсрэг эмчилгээ
9. Тархины бодисын солилцоог сайжруулах эмчилгээ
10. Биемахбод болон сэтгэцийг сэргээх эмчилгээ
11. Сэтгэц нөлөөт бусад эмээр эмчлэх эмчилгээ
12. Инсулинээр эмчлэх эмчилгээ
13. Нойроор эмчлэх эмчилгээ

**Сэтгэц нийгмийн нөхөн сэргээх эмчилгээ (Psychosocial rehabilitation F08Z6ZZ)**

1. Сэтгэцийн эрүүл мэндийн нийгмийн тусламж үйлчилгээ, нийгэм хамт олонд суурилсан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай орчин цагийн ойлголт, тусламж үйлчилгээний хэлбэрүүд,
2. Сэтгэц - нийгмийн реабилитаци, реабилитацийн үе шатууд, реабилитацийн зарчмууд
3. Нийгмийн эмчилгээ, эмнэлгийн орчноор эмчлэх эмчилгээ, эмчилгээний хамт олон /бүлэг/ - Нэр хаяггүй, архичдын нөхөрлөл, наркомануудын нөхөрлөл, нэр хаяггүй идэмхий хүмүүсийн нөхөрлөл, нэр хаяггүй истерикүүдийн нөхөрлөл, мөрийтэй тоглоомонд дондох өвчтэй хүмүүсийн нөхөрлөл, эмчилгээний бусад нөхөрлөл.
4. Эмнэлэг-хамгааллын дэглэм: Ерөнхий ойлголт, эмнэлэг хамгааллын дэглэмийг баримтлах, мөрдөх ерөнхий хандлагууд, хавчлагагүй байх тогтолцоо
5. Сэтгэцийн эрүүл мэндийн нийгмийн тусламж үйлчилгээ: Нийгэм хамт олонд суурилсан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай орчин цагийн ойлголт, тусламж үйлчилгээний хэлбэрүүд
6. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, түүний шатлал
7. Сэтгэцийн эрүүл мэндийн сэргийлэлт: Сэтгэцийн сэргийлэлтийн ерөнхий ойлголт, сэтгэцийн эрүүл мэндийн анхдагч, хоёрдахь, гуравдахь сэргийлэлт

8. Сэтгэцийн эрүүл мэндийн эрүүл ахуй: Нийгмийн харилцааны сэтгэцийн эрүүл ахуй, Гэр бүл, эр эмийн ёсны сэтгэцийн эрүүл ахуй, насны сэтгэцийн эрүүл ахуй, спортын сэтгэцийн эрүүл ахуй, хөдөлмөрийн сэтгэцийн эрүүл ахуй
9. Сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт: Сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын тухай, сэтгэцийн эрүүл мэндийн 1,2,3 дугаар шатлалын боловсрол олгох сургалт
10. Сэтгэцийн эрүүл мэндийн эрх зүйн тусламж, үйлчилгээ: Эрх зүйн тусламжийн хэрэгцээ шаардлага. Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах ба дэмжих чиглэлээр гарсан олон улсын болон үндэсний хууль тогтоомжууд
11. Сэтгэлийн өвчний тархвар судлал: Тархвар судлалын арга, хүн амын сэтгэцийн өвчний өвчинт байдал

**Харих насанд тохиолдох сэтгэцийн эмгэгийн үеийн тусламж (Geratric psychiatry F0#)**

1. Хүний амьдралын мөчлөг, биологи, нийгэм сэтгэл зүйн онцлог
2. Цэвэршилтийн үеийн неврозууд (Organic anxiety disorders F06.4)
3. Өтлөлтийн өмнөх үеийн солиорлууд (Organic hallucinosis F06.0, Organic delusional disorders F06.2)
4. Өтлөлтийн үеийн солиорлууд (Dementia in Alzheimer disease F00; Vascular dementia F01; Dementia in other diseases classified elsewhere F02)
5. Бусад шалтгаант тэнэгрэлүүд (Unspecied dementia F03 Organic amnestic syndrome, not induced by alcohol and other psychoactive substances F04)
6. Харих насанд гарах сэтгэцийн онцлогууд
7. Харих насанд гарах биеийн онцлогууд
8. Харих насны хүнд сэтгэц нөлөөт эмийг сонгох онцлог ба эмчилгээний зарчим
9. Ахмад настаны хүчирхийлэл (Unspecified adult maltreatment, suspected, initial encounter T76.91XA)

***Мэдрэл судлалын ерөнхий ба тусгай эмгэг судлал (General and specific neurology) G0-G9***

1. Мэдрэлийн эрхтэн тогтолцооны бүтэц, үйл ажиллагааны үндсэн зарчмууд
2. Ерөнхий мэдрэхүйн өөрчлөлт
3. Мэдрэлийн өвчний үед сэтгэцийн талаас гарах өөрчлөлтүүд
4. Зонхилон тохиолдох мэдрэлийн эмгэгүүд (Most common neurological disorders G2; G3; G4)
5. Мэдрэлийн эмгэгийн үндсэн хам шинжүүд, байршлын онош зүй
6. Клиникийн мэдрэл судлал дахь шинжилгээний аргууд
7. Комын байдал
8. Мэдрэлийн өвчтөнд үзлэг хийх арга
9. Мэдрэлийн зонхилон тохиолдох эмгэгүүдийг оношлох, ялган оношлох, эмчлэх, яаралтай тусламж үзүүлэх

**Амиа хорлох эрсдэл ба яаралтай тусламж (Intentional self-harm or suicide, emergency care for suicidal attempters X60-X84)**

1. Амиа хорлох, амиа хорлох оролдлого хийхэд нөлөөлөх хүчин зүйлс, шалтгаан
2. Амиа хорлох бодол, төсөөлөл, төлөвлөгөө, оролдлого, далд амиа хорлолт, амиа хорлох зэрэг өвөрмөц нэр томъёоны талаарх ойлголт

3. Амиа хорлох эрсдэлийг үнэлэх аргачлал, амиа хорлох оролдлого хийхдээ түгээмэл ашигладаг аргууд (Intentional self-harm methods X60-X84)
4. Амиа хорлосон болон амиа хорлох оролдлого хийсэн тохиолдлуудын бүртгэлийн тогтолцооны гажуудал, засах аргууд
5. Амиа хорлох оролдлого хийсэн хүмүүст үзүүлэх яаралтай тусламж

### 6.2.3 ГАРДАН ҮЙЛДЛИЙН ЖАГСААЛТ

| № | Гүйцэтгэх гардан үйлдлийн жагсаалт |
|---|---|
| 1 | Тухайн үеийн сэтгэцийн байдлыг тодорхойлох (Mental state examination Z13.39) |
| 2 | Сэтгэцийн эрүүл мэндийн анхан түвшний боловсрол олгох сургалт явуулах (Mental health education Z71) |
| 3 | Дошгиролтой өвчтөний судсанд тариа хийх (Injection or infusion 00.19) |
| 4 | Сэтгэцйин байдал тодорхойлох үзлэг хийж тэмдэглэл хөтлөх (Keep mental patient's documents Z91.14) |
| 5 | Амьдралын болон өвчний түүхийг субъектив, объектив анамнезийн аргаар цуглуулах (Encounter for screening and collect anamnesis Z13.89) |
| 6 | Өвчний түүх нээх, өдөр тутмын тэмдэглэл хөтлөх (Keep medical history Z86.39) |
| 7 | Сэтгэцийн эмгэгүүдийг илрүүлэх, үнэлэх төрөл бүрийн сорилуудыг хэрэглэх, үнэлэх (Encounter for screening and assessment for mental disorders Z13.30) |
| 8 | Өдрийн эмчилгээг хийх (Daycare treatment Y07.511) |
| 9 | Бага, өсвөр насны эмчлүүлэгч, түүний гэр бүлийнхэнд мэдээлэл, зөвлөгөө өгөх (encounter counseling for patients Z71.1) |
| 10 | Бага, өсвөр насны эмчлүүлэгчийн сэтгэцийн байдалд тохируулан эмчилгээ тусламж төлөвлөх (Encounter for other specified care Z51.89) |
| 11 | Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын магадлагаа гаргах (General psychiatric examination, reguested authority Z04.6) |
| 12 | Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын магадлагааны акт бичих (General psychiatric examination, reguested authority Z04.6) |
| 13 | Параклиникийн оношилгооны дүгнэлтийг сэтгэцийн байдлыг тайлбарлаж сурах (Interpretation screening questionnaires, and psychological investigation Z13.39) |
| 14 | Стресс тайлах энгийн аргуудыг ашиглаж, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх (Encounter for counseling, and stress management techniques R45.7; Z71.1) |
| 15 | Сэтгэцийн хурц байдалтай өвчтөнд номхотгох арга хэрэглэх (physical restraint status Z78.1) |
| 16 | Нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй өвчтөнд яаралтай тусламж үзүүлэх (Altered mental status R41.82) |
| 17 | Сэтгэц нөлөөт эмийг жор бичих (Other long-term drug therapy Z79) |
| 18 | Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний заалтыг сэтгэцийн байдалд нь тохируулан тодорхойлох (Psychosocial rehabilitation treatment F08Z6ZZ) |
| 19 | Мэдрэлийн эмгэгүүдийг оношлох, эмчлэх (Encounter for screening for other nervous system disorders Z13.858) |
| 20 | ЭЭГ-ийн бичлэг унших (Abnormal EEG R94.01; Z13.858) |
| 21 | Гавал, нуруу ясны рентген зураг унших (Diagnostic imaging R93.9; Z13.83) |
| 22 | Тархины судасны бичлэгийн шинжилгээний хариу унших (Encounter for screening for other nervous system disorders Z13.858) |
| 23 | Нугасны ус авах хатгалт хийх (Spinal tap 03.31) |
| 24 | Эпилепсийн статусын эмчилгээ (Treatment in status epilepticus G40.901) |

| | |
|---|---|
| 25 | Мэдрэлийн төгсгөлд хориг тавих эмчилгээг хийх (Injection of anesthetic into peripheral nerve for analgesia 04.81 |
| 26 | Амиа хорлох оролдлого хийсэн хүнд яралтай тусламж үзүүлэх (Emergency care for suicide attempters E950-959) |
| 27 | Гуурсаар хооллох (Enteral infusion of concentrated nutritional substances 96.6) |
| 28 | Эмчилгээний болон цэвэрлэх бургуй тавих (Nonoperative alimentary tract irrigation, cleaning, and local instillation 96.3) |

### 6.2.4. Тойролтын хуваарь:

| № | Тойролтын нэр | Хугацаа | Тойролт явагдах тасаг нэгж |
|---|---|---|---|
| 1 | Ерөнхий сэтгэцийн эмгэг судлал | 12 долоо хоног | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, II-VI клиник, поликлиникийн үзлэгийн кабинет |
| 2 | Донтолт судлал | 8 долоо хоног | Донтолт судлалын клиник, үзлэгийн кабинет |
| 3 | Хүүхэд, өсвөр үеийн сэтгэцийн эмгэг судлал, хэл засал | 8 долоо хоног | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв Хүүхэд өсвөр үеийн клиник, үзлэгийн кабинет, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Нийслэлийн Хүүхдийн сэргээн засах төв |
| 4 | Шүүхийн сэтгэцийн эмгэг судлал, параклиник шинжилгээ | 8 долоо хоног | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв VII клиник, шүүхийн сэтгэцийн үзлэгийн кабинет |
| 5 | Сэтгэцийн өвчтөнд үзүүлэх яаралтай тусламж | 8 долоо хоног | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв хүлээн авах, яаралтай тусламжийн клиник, Нийслэлийн яаралтай тусламжийн төв |
| 6 | Сэтгэцийн завсрын ба бэлгийн эмгэг судлал, сэтгэл засал | 12 долоо хоног | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв Стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэгийн клиник, сэтгэл засал эмчилгээний баг |
| 7 | Сэтгэц нөлөөт эм судлал | 6 долоо хоног | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв сэтгэц нөлөөт эмийн алба |
| 8 | Сэтгэц нийгмийн нөхөн сэргээх тусламж | 6 долоо хоног | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв II-VI клиник, сэтгэц нийгмийн нөхөн сэргээх эмчилгээний тасаг |
| 9 | Харих насны сэтгэцийн эмгэг судлал | 4 долоо хоног | Геронтологийн Үндэсний Төв |
| 10 | Мэдрэл судлал | 8 долоо хоног | Монгол Японы эмнэлэг, Улсын нэгдүгээр төв эмнэлэг |
| 11 | Амиа хорлох эрсдэл ба яаралтай тусламж | 8 долоо хоног | Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв 1800-2000 утас |
| 12 | Нийт | 88 долоо хоног | |

**Загвар 1.**

**Ажлын байрны сургалт (On-the-Job Training)**

| Аргачлал | Суралцагч эмчийн тоо | Үргэлжлэх цаг, давтамж | Сургалт явагдах газар | Үйлчлүүлэгч/ Хэрэглэгдэхүүн | Удирдагч, хамтрагч |
|---|---|---|---|---|---|
| **Амбулаторийн тойрон үзлэг хийх** | 1 | 3 цаг 7 хоногт 2 удаа | Амбулатори | Үйлчлүүлэгч | Эмнэлзүйн сургагч багш |
| **Хяналтын тойрон үзлэг хийх** | 3-5 | 1 цаг Өдөр бүр | Тасаг | Үйлчлүүлэгч | Эмнэлзүйн сургагч багш |
| **Сургалтын тойрон үзлэг хийх** | 20 хүртэл | 1 цаг 7 хоногт 1 удаа | Сургалтын өрөө, танхим | Компьютер, проектор | Зөвлөх эмч-багш, эмнэлзүйн сургагч эмч-багш, багш-эмч |
| **Яаралтай тусламж үзүүлэхэд оролцох** | 1-2 | Тохиолдол байгаа үед | Яаралтай тусламжийн өрөө | Үйлчлүүлэгч | Эмнэлзүйн сургагч багш |
| **Гардан үйлдэл хийх** | 1-2 | Тохиолдол байгаа үед | Яаралтай тусламжийн өрөө, тасаг, анхаарах өрөө | Үйлчлүүлэгч | Эмнэлзүйн сургагч багш, бусад эмч |

**Хяналтын тойрон үзлэг:**

Хэвтэн эмчлүүлж байгаа үйлчлүүлэгчийн биеийн байдлыг суралцагч эмч нь эмнэл зүйн сургагч багшид (бусад эмч) танилцуулах зорилготой үзлэг.

Үүний тулд суралцагч эмч нь урьдчилан бие даан өвчний түүх, сувилагчийн тэмдэглэлийг үзэж танилцан, үйлчлүүлэгчээс асуумж цуглуулж (ганцаарчилсан үзлэг), эмнэл зүйн сургагч багшид (бусад эмч) танилцуулахад бэлдэнэ. Танилцуулга хийхдээ хувь хүний мэдээллийг анхаарна. Танилцуулгыг сургалтын өрөө, танхим, эсвэл үйлчлүүлэгчийн өрөөнөөс гадна хийх ба үйлчлүүлэгчийн орны дэргэдэх тойрон үзлэгийг эмнэл зүйн сургагч багштай (бусад эмч) хамт хийнэ. Хяналтын тойрон үзлэгээр үйлчлүүлэгчээс асуумж авах, үзлэг хийх аргад суралцана.

**Сургалтын тойрон үзлэг:**

Сургалтад тохиромжтой 1-2 үйлчлүүлэгчийг сонгож, үйлчлүүлэгчийн биеийн байдлыг суралцагч эмч нь танилцуулах ба бусад оролцогчид (хамтран суралцагч эмч, эмнэл зүйн сургагч багш, бусад эмч) асуулт тавьж, хэлэлцүүлэг өрнүүлнэ.

1 тохиолдолд 30-60 минут зарцуулна. Үүний дараа үйлчлүүлэгчийн орны дэргэд үзлэг хийнэ. Хэлэлцүүлгийн явцад эмнэл зүйн таамаглал дэвшүүлэх, онош тавих зэрэгт суралцана.

**Загвар 2.**

**Танхимын сургалт (Off-the-Job Training)**

| Аргачлал | Суралцагч эмчийн тоо | Үргэлжлэх цаг, давтамж | Сургалт явагдах газар | Хэрэглэгдэхүүн | Удирдагч, хамтрагч |
|---|---|---|---|---|---|
| **Бие даалт** | 1 | Тохиромжтой чөлөөт цаг | Гэртээ, номын сан | Ном, интернэт | Өөрөө, хамтран суралцагч эмч |
| **Лекц** | 20 хүртэл | 1-2 цаг 7 хоногт 4-5 удаа | Сургалтын анги, танхим | Компьютер, проектор | Эмнэлзүйн сургагч багш-эмч, суралцагч эмч |
| **Журнал клуб** | 20 хүртэл | 1 цаг 7 хоногт 1 удаа | Сургалтын анги, танхим | Компьютер, проектор, эрдэм шинжилгээний өгүүлэл | Эмнэлзүйн сургагч багш-эмч, суралцагч эмч |
| **Симуляци (дуураймал орчин)** | 5 хүртэл | 7 хоногт 1 удаа 1 цаг | Яаралтай тусламжийн өрөө | Хамтран суралцагч эмч, манекин | Эмнэл зүйн сургагч багш |

**Загвар 3.**

**Үйл ажиллагааны хуваарь**

| Цаг | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан |
|---|---|---|---|---|---|
| 08:00-09:00 | Ганцаарчилсан үзлэг | Ганцаарчилсан үзлэг | Ганцаарчилсан үзлэг | Ганцаарчилсан үзлэг | Ганцаарчилсан үзлэг |
| 09:00-10:00 | Хяналтын тойрон үзлэг | Хяналтын тойрон үзлэг | Хяналтын тойрон үзлэг | Хяналтын тойрон үзлэг | Хяналтын тойрон үзлэг |
| 10:00-13:00 | Лекц | Лекц | Лекц | Лекц | Лекц |
| 13:00-14:00 | Бие даалт | Семинари | Бие даалт | Семинари | Бие даалт |
| 14:00-15:00 | Сургалтын тойрон үзлэг | Хүлээн авах, Яаралтай тусламж, амбулатори | Сэтгэцийн үзлэг | Хүлээн авах, Яаралтай тусламж, амбулатори | Сэтгэцийн үзлэг |
| 15:00-17:00 | | | Эмнэлзүйн хэлэлцүүлэг | Сургалтын тойрон үзлэг | Журнал клуб |

## ДОЛОО. ҮНЭЛГЭЭ, ЭРГЭН ЗӨВЛӨГӨӨ

### 7.1 Суралцагч эмч ба хариуцагч

Сургалтын 2 жилийн хугацаанд суралцагч эмч бүрт хэрхэн ахин дэвшиж байгаа, хэрхэн сайжруулах тухай эргэн зөвлөгөө өгөх, суралцагч эмчийн хувийн төлөвлөгөөний (career plan) талаар зөвлөлдөх, тэднийг хариуцан ажиллах хүн

(mentor) цаашид “хариуцагч” гэхийг оноож хуваарилна. Суралцагч эмч нь сургалт эхлэх үед хариуцагчтай уулзах ба цаашид 2-3 сар тутамд 1 удаа уулзаж ярилцан, үнэлгээтэй танилцаж, эргэн зөвлөгөө авна.

### 7.2 Суралцагч эмч ба эмнэл зүйн сургагч багш

Суралцагч эмчийн тойролт бүрт сургалт удирдах эмнэл зүйн сургагч багш оноож хуваарилна:

- Суралцагч эмч нь тухайн тойролт эхлэхээс өмнө эмнэл зүйн сургагч багштай уулзаж, тойролтын хугацаанд тавьсан зорилтоо ярилцана.
- Суралцагч эмч нь тойролтын явцад тавьсан зорилтод хүрэхийн тулд дутагдаж байгаа зүйл, түүнийг нөхөхөд хэрэгцээтэй байгаа зүйлийн тухай эмнэл зүйн сургагч багштай ярилцана.
- Суралцагч эмч нь тойролт дуусахад эмнэл зүйн сургагч багштай ярилцлага хийж, сургалттай холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө авна.

### 7.3 Үнэлгээний арга

#### 7.3.1 Төгсөлтийн шалгалт

Төгсөлтийн шалгалт нь онолын болон гардан үйлдлийн хэсгээс бүрдэх бөгөөд сургалтын эцсийн үнэлгээ нь явц:шалгалтын үнэлгээний харьцаа 80:20 байхаар тооцно.

| № | Үнэлгээ хувиар | Үсгэн үнэлгээ | Үнэлгээний оноо (0-4) | Үнэлгээний болзол |
|---|---|---|---|---|
| 1 | 90-100 | A | 4.0 | Тухайн сургалтын агуулгыг бүрэн бүтээлчээр ойлгож, мэдлэг эзэмшсэн, эзэмшсэн мэдэлгээ чадварлаг ашиглаж чаддаг байх |
| 2 | 80-89 | B | 3.0 | Тухайн сургалтын агуулгыг сайн ойлгож, мэдлэг эзэмшсэн, эзэмшсэн мэдэлгээ үйл ажиллагаандаа хэрэглэж чаддаг байх |
| 3 | 70-79 | C | 2.0 | Тухайн сургалтын агуулгыг хангалттай хэмжээний ойлголт, авсан, холбогдох энгийн даалгаварыг хийж гүйцэтгэх чадвартай бөгөөд цаашдаа тухайн сургалтыг гүнзгийрүүлэн судлах бэлтгэлтэй болсон байх |
| 4 | 60-69 | D | 1.0 | Тухайн сургалтын агуулгыг жигд ойлгоогүй харьцангуй хялбар ажилбаруудыг хийж гүйцэтгэх чадвартай бөгөөд цаашдаа тухайн сургалтыг гүнзгийрүүлэн судлахын тулд нэмэлт даалгавар хийж гүйцэтгэх шаардлагатай |
| 5 | 0-59 | F | 0.0 | Мэдлэг, чадвар, дадал хангалтгүй байх |

#### 360 хэмийн үнэлгээ (360-Degree Assessment)

Суралцагч эмчийн мэргэжлийн, зохион байгуулагч, манлайлагч байх зэргийг үнэлэхэд хэрэглэнэ. 2 жилийн сургалтын дунд үе болон төгсөх үед хийнэ. Тойролтыг удирдсан эмнэл зүйн сургагч багш, сувилахуйн мэргэжилтэн, тухайн тасаг, нэгжийн хамтран ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгч зэрэг нийт 5 хүн тус тусдаа үнэлнэ. Үнэлгээ хийх хүнийг сургалтын алба сонгоно. Үнэлгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагчид өгнө.

**Портфолио үнэлгээ (Portfolio Assessment):**

Суралцагч эмч нь сургалтын хугацаанд суралцсан лекц, эмнэлгийн анхан, үндсэн, төрөлжсөн тусламж үйлчилгээний сургалтын үеэр эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа хийсэн материал зэрэг сургалттай холбоотой бусад бичиг баримтыг үр дүн болгож хадгална.

**Форматив CbD (Case based Discussion) үнэлгээ**

Суралцагч эмч нь сургалтын явцад 5-аас доошгүй удаа "Академик өвчний түүх" бичсэн байх бөгөөд үүнийг нь хариуцагч эмч, багш үнэлнэ.

**VSOP үнэлгээ**

Суралцагч эмчийн сургалтын явцад бэлтгэсэн эмнэл зүйн тохиолдлуудыг хариуцагч эмч багш нь үнэлнэ.

**Явцын MINI-CEX үнэлгээ**

Суралцагч эмч тойролт бүрт 5-аас доошгүй шинж тэмдгийг 3 ба түүнээс дээш удаа сургагч багшаар дүгнүүлнэ.

**DOPS үнэлгээ**

Гардан үйлдлийг хийж чаддаг болтлоо сургагч багшаар үнэлүүлнэ.

**Эмчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ**

Суралцагч эмчийн эмчлүүлэгчийн сэтгэл ханамжийг жилд 2-оос доошгүй удаа үнэлнэ.

### 7.4 Үнэлгээний дүнг хянах

- 360 хэмийн үнэлгээний дүнг сургалтын алба хяналт тавьж, хадгална. Үнэлгээний дүнг суралцагч эмч, хариуцагчид танилцуулах ба бусадтай хуваалцахгүй байхыг анхааруулна.
- Портфолиод үнэлгээ, эмнэл зүйн сургагч багштай зөвлөлдсөн асуудал, өгсөн зөвлөгөөг бичиж тэмдэглэн хадгална.
- Форматив CbD (Case based Discussion), VSOP үнэлгээний дүнг сургалтын алба хяналт тавьж, хадгална. Үнэлгээний дүнг суралцагч эмч, хариуцагчид танилцуулах ба бусадтай хуваалцахгүй байхыг анхааруулна.
- Эмчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээг сургалтын алба хадгална.
- Сургалтын алба үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд танилцуулах ба сургалтын төгсгөлд хариуцагчаас суралцагч эмчид зөвлөгөө өгнө.

### 7.5 Сургалтын төгсөлтийг шийдвэрлэх

- Сургалтын хяналтын зөвлөл нь тойролт бүрт хийгдсэн 360 хэм, Форматив CbD (Case based Discussion), VSOP, Эмчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээнүүдийн нэгдсэн дүн, суралцагчийн сургалтын ирц, зайлшгүй таньж мэдэж суралцах шинж тэмдэг, өвчний тохиолдол, гардан үйлдлийн тоог харгалзан сургалтын төгсөлтийн эцсийн шийдвэрийг гаргана. Шийдвэр гаргах шалгуур нь:

- Зайлшгүй сургалтад оролцсон байх өдрийн тоо буюу сургалтын ирц. Хөдөлмөрийн тухай хуульд заасан цалинтай амралтын өдрийн тоо, хүндэтгэх шалтгаантай авах амралтын өдрийн тоог оруулаад сургалтын хугацаанд авах амралтын өдрийн тоог сургалтын тойролт тус бүрийн нийт өдрийн 20%-аас хэтрүүлэхгүй байна. Сургалтын ирц хангалтгүй бол тухайн тасарсан сургалтын өдөр, агуулгыг нөхүүлнэ.

- Тойролт бүрийн төгсгөлд эсвэл 2 жилийн сургалтын эцэст суралцагчийг төгсгөх боломжгүй гэсэн шийдвэр гарсан тохиолдолд шалтгаан, цаашид сургалтыг хэрхэн төгсгөх талаарх шийдвэр, зөвлөмжийг сургалтын алба болон хариуцагчаас тухайн суралцагч эмчид тайлбарлаж өгнө.
- Сургалтын 2 жилийн хугацаанд тухайн суралцагч эмчийн явцын болон улирлын тайлан хамгаалалтын үнэлгээ 80-аас дээш байгаа тохиолдолд төгсөлтийн шалгалтанд орохыг зөвшөөрнө.

## НАЙМ. ХЭРЭГЖҮҮЛЭЛТ
## (хөтөлбөрийг нэвтрүүлэх ба хэрэгжүүлэх)

### 8.1 Сургалтын хяналтын зөвлөл

- Тэнхмийн эрхлэгч, сургалт хариуцсан зохицуулагч багш-эмч, эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагын дэд дарга, тухайн тойролтын сургалт хариуцагч, сувилахуйн албаны төлөөлөл, эмнэлгийн захиргааны албаны төлөөлөл, суралцагч эмчийн төлөөллөөс бүрдэнэ. Сургалтын хяналтын зөвлөл нь тэнхимийн эрхлэгч–профессор, эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагын даргын шууд удирдлага дор ажиллана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь сар бүр хуралдана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь суралцагч эмчийн сургалт, тулгарсан асуудалтай танилцах, суралцагч эмчтэй холбоотой бүх асуудлыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг судалдаг бүтэц байна.
- Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд нь сургалтыг илүү сайжруулахын тулд өөрийн мэдлэг, боловсролоо дээшлүүлэхийг зорьж ажиллана.

### 8.2 Хөтөлбөрийн хяналт

- Сургалтын алба хөтөлбөрт хяналт хийнэ.
- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнэл зүйн сургагч багшид чиглэсэн сургалт, суралцагч эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.
- Хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд сургалтын хяналтын зөвлөлд оруулж хэлэлцүүлэн, өөрчлөлт хийнэ. Энэ тухай Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлд албан бичгээр ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.

### 8.3 Сургалтын танилцуулга

Сургалт эхлэхийн өмнө тойролт бүрийн сургалтын төлөвлөгөө болон хөтөлбөрийн агуулгын уялдааг тодорхой ойлгох, сургалт эрхлэх байгууллага, түүний үйл ажиллагаа, эмчилгээ, оношилгооны аюулгүй байдал, халдвар хамгааллын тухай суралцагч эмчид гүнзгий ойлголт өгөх зорилго бүхий танилцуулга хичээлийг зохион байгуулна.

**Хавсралт 1**

# 360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Суралцагч эмчийн нэр_______________________________

Үнэлгээ хийгч: ☐ Эмнэл зүйн сургагч багш ☐ Сувилагч ☐ Бусад__________

*Суралцагч эмчийг ажигласны үндсэн дээр, бусдаас сонссон, мэдсэн зүйл дээр бус, суралцагч эмчийн зан үйлийг хэр давтамжтай байсныг өөрийнхөө ажигласнаар оноо тавина уу.*

| ☐ NA | ☐ 1 | ☐ 2 | ☐ 3 | ☐ 4 |
|---|---|---|---|---|
| Үнэлэх боломжгүй | Ховор (<19%) | Заримдаа (20-49%) | Ихэнхидээ (50-79%) | Бараг бүгд (>80%) |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Үйлчлүүлэгч, гэр бүлийн хувийн асуудлыг хүндэтгэдэг | ☐ NA | ☐ 1 | ☐ 2 | ☐ 3 | ☐ 4 |
| Эмнэлгийн бичиг баримтыг бүрэн гүйцэд, гаргацтай, цаг хугацаанд нь хөтөлдөг. | ☐ NA | ☐ 1 | ☐ 2 | ☐ 3 | ☐ 4 |
| Хүн амын эрүүл мэндийн асуудалд өөрийн санаачлагаар хувь нэмрээ оруулдаг | ☐ NA | ☐ 1 | ☐ 2 | ☐ 3 | ☐ 4 |
| Үйлчлүүлэгчийн бие даасан байдлыг хүндэтгэж, үйлчлүүлэгчид тохирсон хамгийн зөв шийдвэрийг гаргахыг хичээн зүтгэл гаргадаг | ☐ NA | ☐ 1 | ☐ 2 | ☐ 3 | ☐ 4 |
| Хувь хүний онцлогийг харгалзан үйлчлүүлэгчийг хүндэтгэн эмчилдэг. | ☐ NA | ☐ 1 | ☐ 2 | ☐ 3 | ☐ 4 |
| Өөрийн эмгэлзүйн ур чадварыг дээшлүүлэхийн тулд сургалт болон бусад боломжийг алдалгүй ашигладаг | ☐ NA | ☐ 1 | ☐ 2 | ☐ 3 | ☐ 4 |
| Өөрийн анагаах ухааны онолын мэдлэгээ дээшлүүлэхийн тулд бие даан суралцдаг | ☐ NA | ☐ 1 | ☐ 2 | ☐ 3 | ☐ 4 |
| Бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажилладаг | ☐ NA | ☐ 1 | ☐ 2 | ☐ 3 | ☐ 4 |
| Эмнэлэг доторх бусад эмч, мэргэжилтэнтэй хамтран ажилладаг. | ☐ NA | ☐ 1 | ☐ 2 | ☐ 3 | ☐ 4 |
| Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйг ухамсарладаг | ☐ NA | ☐ 1 | ☐ 2 | ☐ 3 | ☐ 4 |
| Эмнэлэг доторх тусламж үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйгээ ухамсарладаг. | ☐ NA | ☐ 1 | ☐ 2 | ☐ 3 | ☐ 4 |

1 эсвэл 4 оноо тавьсан бол тухайн асуултын дагуу саналаа бичнэ үү.

Дүгнэлтийг тодорхой бичих хэрэгтэй. Жишээ нь: "Тэр бол найдваргүй" гэх нь тодорхой биш. Илүү хэрэг болох дүгнэлт бол: "Тэр сүүлийн 3 удаагийн журнал клубын 2-т нь хэн нэгэнд урьдчилан мэдэгдэлгүйгээр оролцсонгүй."

Өөрөөсөө асуу: **"Миний дүгнэлт цаашид сайжрахад нь суралцагч эмчид хэрэг болох болуу?"**

**Хавсралт 2**

# ФОРМАТИВ CBD (CASE BASED DISCUSSION) ХУУДАС
(ӨВЧНИЙ ТҮҮХИЙН ҮНЭЛГЭЭ)

Үнэлгээ хийсэн огноо / /

Суралцагчийн нэр: ____________________ Үнэлгээ өгөгч: ________________

Эмнэлэг:________________ Хэсэг____________ Орчин: □Клиник □Тасаг □ ED □Бусад

Өвчтөний нас ___ өвчтөний хүйс: □ эр □ эм

Тохиолдлын хэцүү байдал: □ бага □ дунд □ өндөр

| | Хангалтгүй | Хангалттай | Дээд | Шалгаагүй |
|---|---|---|---|---|
| 1. Паспортын хэсэг | 1 2 3 | 4 5 6 | 7 8 9 | |
| 2. Амьдралын түүх | 1 2 3 | 4 5 6 | 7 8 9 | |
| 3. Өвчний түүх | 1 2 3 | 4 5 6 | 7 8 9 | |
| 4. Одоогийн сэтгэцийн байдал | 1 2 3 | 4 5 6 | 7 8 9 | |
| 5. Онош, оношийн үндэслэл | 1 2 3 | 4 5 6 | 7 8 9 | |
| 6. Эмчилгээний төлөвлөгөө | 1 2 3 | 4 5 6 | 7 8 9 | |
| 7. Хөтлөх удирдамж | 1 2 3 | 4 5 6 | 7 8 9 | |
| Нэгдсэн үнэлгээ болон эмнэл зүйн тусламж | 1 2 3 | 4 5 6 | 7 8 9 | |

Давуу тал

Өвчний түүх бичилтийг сайжруулахын тулд өгөх зөвлөмж
Хэрэв суралцагч нь хангалтгүй гэж үнэлэгдсэн бол, үнэлгээ өгөч нь энэ хэсгийг бөглөх ёстой.

Өвчний түүх шалгахад зарцуулсан хугацаа:____ минут

Эргэх хугацаанд зарцуулсан цаг хугацаа:____ минут

| | |
|---|---|
| Үнэлгээ өгөгчийн CbD ашигласан сэтгэл ханамж | (бага ) 1 2 3 4 5 6 7 8 9 (өндөр) |
| Суралцагчийн CbD ашигласан сэтгэл ханамж | (бага ) 1 2 3 4 5 6 7 8 9 (өндөр) |

Үнэлгээ өгөгчийн гарын үсэг ______________ Суралцагчийн гарын үсэг _______________

**Хавсралт 3**

# VSOP ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
## (ЭМНЭЛ ЗҮЙН ТОХИОЛДЛЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ)

Үнэлгээ хийсэн огноо / /

Суралцагчийн нэр: ____________________ Үнэлгээ өгөгч:________________

Эмнэлэг:______________ Хэсэг____________ Орчин: □ Клиник □ Тасаг □ ED □ Бусад

Өвчтөний нас_________ өвчтөний хүйс: □эр □ эм

| Хамгийн магадлалтай онош | Ялган оношилгооны түлхүүр (ЯОТ-KDDs) | Сайжруулах зүйлүүд | VSOP |
|---|---|---|---|
| | | | |

Үнэлгээ өгөгчийн гарын үсэг:______________ Суралцагчийн гарын үсэг:_______________

| | **Илтгэлийн байдал** | **Илтгэгчийн түвшин** | **Суралцагчаас илтгэгчид өгөх эргэх холбоо** |
|---|---|---|---|
| Vague<br>Тодорхой биш | Тодорхой биш илтгэл нь хангалтгүй эсвэл дэс дараагүй мэдээллээс эсвэл агуулгаа муу илэрхийлсэнтэй холбоотой | Мэдээлэл цуглуулах эсвэл бүтэц нь системтэй бус. Тохиолдол танилцуулахад сургуулилт хийх хэрэгтэй. | Тохиолдол танилцуулахад юуг орхисныг тэмдэглэх. Суралцагчид нэг нэгээр нь дадлага хийхийг хэлэх |
| Structured<br>Төлөвлөгдсөн | Тохиолдлын илтгэл нь ердийн H&P мэдээллийн бүтэцтэй гэвч ЯОТ нь дутагдалтай. | Тохиолдлын талаарх мэдээллийг танилцуулах чадвартай гэвч бүх ЯОТ-нд өвчтөний асуудлын жагсаалт гаргах чадваргүй. | Мэдээллийг гүйцээхэд эерэг дүгнэлт өгөх. Илтгэгчээс ЯОТ-ний талаар нэмэлтээр асуух. Хэрэв үгүй бол, илтгэгч нь ЯО-г өргөн хүрээнд биш байхаар төлөвлөнө. |
| Organized<br>Зохион байгуулагдсан | ЯОТ нь бүгд жагсаалтад бичигдсэн ба тохиолдол дахь H&P мэдээлэлтэй зохион байгуулагдсан гэвч эерэг болон сөрөг тохиромж S/S хангалтгүй. | H&P-ийн үе дэх ЯОТ хийхэд хамааралгүй S/S байх. During H&P no relevant S/S to KDDs obtained. | ЯОТ-д эерэг дүгнэлт өгөх ба тохиромжтой эерэг болон сөрөг S/S-д засаж болохуйц дүгнэлт өгөх. Give positive feedback for KDDs and corrective feedback for pertinent positive and negative S/S |
| Pertinent<br>Тохиромжтой | Тохиромжтой эерэг болон сөрөг S/S нь ЯОТ-д хамаарч шийдвэрлэгдэх pertinent positive and negative S/S relevant to KDDs are covered | H&P-ийн үед тохиолдлын бүх хэсэг болох ЯОТ-д эдгээр нь тодорхой орсон байх. Through H&P whole picture of the case and its KDDs are clearly described | Сайн илтгэлд эерэг дүгнэлт өгөх. Илтгэгчээс тохолдлоос сурсан зүйлийн талаар тодруулах. Give positive feedback for KDDs and corrective feedback for presentation. Ask the presenter tk specify the lessons learned from the case. |

H&P Асуумж & бодит үзлэг, S/S: шинж тэмдэг ба хам шинж, KDD (ЯОТ): key Differential Diagnoses

**Хавсралт 4**

## ГАРДАН ҮЙЛДЛИЙН УР ЧАДВАРЫН ШУУД АЖИГЛАЛТ (DOPS) ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Он, сар, өдөр / /

Суралцагчийн нэр: ___________________ Үнэлгээ өгөгч: ________________

Эмнэлэг:_______________ Хэсэг____________ Орчин: □Клиник □Тасаг □ ЯТТ □Бусад

Гардан үйлдэл: □ Асуумж авах, цуглуулах □ Түүх нээх, хөтлөх □ Одоогийн сэтгэцийн байдлыг тодорхойлох үзлэг хийх □ Сэтгэцийн байдлын үнэлгээ хийх □ Ялган оношилгоо □ Оношийн үндэслэл гаргах □ Өвчтөн хөтлөх удирдамж төлөвлөх □ Үйлчлүүлэгч, эмчлүүлэгч түүний асран хамгаалагчид мэдээлэл зөвлөгөө өгөх □ Эмнэлэг хамгаалын дэглэм □ Эмчлүүлэгч зөөвөрлөх □ Номхотгох тусламж үйлчилгээ □ Тайвшруулах булчин сулруулах дасгалууд □ Бүлгийн сэтгэл засал □ Өөреөс гаралтай дасгал □ Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээ

Одоог хүртэл суралцагч эмчийн тухайн гардан үйлдлийг хийсэн тоо ______________

| Үнэлгээ | Хангалтгүй | Завсрын | Хангалттай | Ажиглагдаагүй/ үнэлэх боломжгүй |
|---|---|---|---|---|
| Одоогийн зовуурь шаналгааг асуусан уу? | | | | |
| Удамд нь сэтгэцийн эмгэгтэй эсвэл оюуны хомсдолтой хүн байсан эсэх? | | | | |
| Айлын хэддэх хүүхэд, эцэг эхийн хэдэн насанд төрсөн, төрөлт хоорондын зайг тодруулсан эсэх? | | | | |
| Эх жирэмслэхээс өмнө эцэг эх хорт зуршилтай байсан эсэх эсвэл биемахбодын ямар нэгэн эмгэгтэй байсан эсэх? | | | | |
| Эхийн жирэмсэн үеийн сэтгэцийн болон биеийн байдлыг тодруулсан эсэх | | | | |
| Хүүхэд төрөх үеийн байдлыг тодруулсан эсэх | | | | |
| Хүүхдийн бага насны өсөлт хөгжил ямар байсныг тодруулсан эсэх | | | | |
| Хүүхэд 3 хүртэлхи насандаа ямар өвчнөөр өвчилж байсныг тодруулсан эсэх? | | | | |
| Биемахбодын талаас оношилогдсон өвчин бий юу? Төрөлийн гаж хөгжил, биемахбодын согог гэх мэт | | | | |
| Үйлчлүүлэгчийн мар нэг багажийн болон лабораторийн шинжилгээ хийлгэж байсан уу? | | | | |
| Ямар нэг эмчийн хяналтанд эмчилгээ хийлгэдэг үү? Эмчилгээний үр дүн ямар байсан бэ? гэх мэт | | | | |
| **Гардан үйлдэл хийх ерөнхий чадвар** | | | | |

Зөвлөмж:

Сайн тал:

Муу тал:

Бусад санал:

Сайжруулахын тулд зөвшилцөж, биелүүлэх үйлдэл:

Үнэлгээ өгөгчийн гарын үсэг _____________ Суралцагчийн гарын үсэг_____________

**Хавсралт 5**

## ЭМЧЛҮҮЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Үнэлгээ хийсэн огноо / / Суралцагчийн нэр_________________

Өвчтөний нас ___ өвчтөний хүйс: □ эр □ эм

Таныг эмч үзэхдээ хэрхэн үзсэн бэ?

| Асуулт | Муу | Боломжийн | Сайн | Маш сайн | Онцгой | N/A |
|---|---|---|---|---|---|---|
| Таньд бүгдийг хэлсэн:итгэлтэй байх, илэн далангүй болон шулуухан: таны мэдэх ёстой зүйлийг орхиогүй | | | | | | |
| Таньтай эелдэгээр мэндэлсэн: таны хүссэн нэрээр нэрлэх, хэзээ ч бүдүүлэг зан гаргаагүй | | | | | | |
| Таньтай нэг түвшинд харьцаж, хэзээ ч доош нь хийхгүй, таньтай хүүхэд мэт харьцах | | | | | | |
| Таныг ярьж байх үед: анхааралтай сонсдог, утга агуулга бүхий асуулт асуудаг, таныг ярьж байхад яриаг нь таслаагүй | | | | | | |
| Таныг хүн гэдэг талаас нь анхаарч: таныг юм хэлэх үед залхах эсвэл ойшоохгүй үйлдэл гаргаагүй | | | | | | |
| Эмчийн үзлэг хийж байхдаа юуг яагаад хийж байгааг тайлбарлан, юу илэрсэн талаар хэлэх | | | | | | |
| Таньтай хэлэлцэх үед: таны саналыг асуух, сонголтыг санал болгох ба шийдвэр гаргахад туслах, юу хийхээсээ өмнө таниас юу гэж бодож байгааг нь асуух | | | | | | |
| Асуулт асуухад таныг урамшуулах, тэдгээрт тодорхой хариулт өгөх, асуултыг нь хэзээ ч үл ойшоох эсвэл заах | | | | | | |
| Өөрт тань байгаа асуудлуудын талаар таны мэдэж байх зүйлийг тайлбарлах, хэрхэн мөн яагаад бий болсон, дараагийн алхамын талаар тайлбарлах | | | | | | |
| Таны асуудлууд болон эмчилгээний талаарх ойлгомжгүй үг хэллэг ашиглах, аливаа техникийн эмнэлгийн нэр томъёог ойлгомжтой хэлээр тайлбарлах | | | | | | |

N/A: боломжгүй

Үнэлгээ өгөгчийн гарын үсэг _____________ Суралцагчийн гарын үсэг_____________

## НОМ ЗҮЙ


***Сурах бичиг:***

1. С.Бямбасүрэн, Ш.Доржжадамба “Шүүхийн сэтгэцийн гэм судлал” УБ хот 1990
2. С.Бямбасүрэн “Сэтгэц судлал” УБ хот 2007 он
3. Д.Болдцэрэн “Секс судлалын үндэс” 1,2-р боть УБ хот 1994 он
4. Д.Болдцэрэн ”Анагаах ухааны секс судлал” 3-р дэвтэр, 1996он
5. Ц.Гүрдорж, З.Хишигсүрэн. “Ерөнхий сэтгэц судлал” Улаанбаатар. 2020 он.
6. Ш.Доржжадамба “Сэтгэцийн өвчнүүд” УБ хот 1993 он
7. Н.Орёл "Эмгэг сэтгэл судлал" УБ хот 1979 он
8. З.Хишигсүрэн, Д.Оюунсүрэн “Амиа хорлох төрх үйлээс урьдчилан сэргийлэх нь”. Амь аврах тусламж үзүүлэгч эмч мэргэжилтэнд зориулсан гарын авлага. Улаанбаатар, 2020 он
9. З.Хишигсүрэн, Х.Тэргэл, Х. Эрдэнэбаатар. “Сэтгэцийн синдром” Улаанбаатар. 2020 он.
10. З.Хишигсүрэн “Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээ” УБ. 2013 он
11. Л.Эрдэнэбаяр "Сэтгэцийн эрүүл мэнд судлалын лекцүүд" УБ хот 2010 он
12. Л.Эрдэнэбаяр “Сэтгэц судлал” УБ хот 2011 он
13. И.Каплан, Б.ДЖ.Сэдок “Клиническое руководство” 1994г Том 1,2
14. Майкл Гельдер, Деннис Гэт, Ричард Мейо “Оксфордское руководство по психиатрии” Том 1,2 1999г
15. Всемирная Организация Здравоохраннения: “Психические расстройства: глоссарий и руководство по их классификации в соответствии с девятым пересмотром Международной классификации болезней” Женева
16. World Health Organization: International Statistical Classification of Diseases and Related Health Problems, TenthRevision. Three Volumes. Geneva: WHO,1992,1993,1994

***Нэг сэдэвт бүтээл:***

1. С.Бямбасүрэн “Мансуурал судлал” 1,2-р хэсэг УБ хот 1999 он
2. С.Бямбасүрэн “Сэтгэцийн өвчтөний сувилахуй ба сэтгэцийн реабилитаци” УБ хот 1999 он
3. С.Бямбасүрэн“Анагаах ухааны хураангуй толь”УБ хот 2000 он
4. С.Бямбасүрэн “Гамшгийн үеийн сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал” УБ хот 2002
5. Д.Болдцэрэн “Эр эмийн ёс” УБ хот 1990 он
6. Т.Ганцэцэг “Стрессийг үүсгэх шалтгаан ба оношлогоо, тусламж” УБ. 2010 он
7. Ц.Гүрдорж, Заиров “Хоол сойх эмчилгээ” УБ хот 1972 он
8. Ц.Гүрдорж “Невроз” 1972 УБ хот он
9. Ш.Доржжадамба “Анагаах ухааны сэтгэл судлал”УБ хот 1977 он
10. Ш.Доржжадамба “Оточ маналын намба төрх” УБ хот 2002 он
11. Лурдес Ладридо-Игнасио, “Нийгэм хамт олонд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ” УБ хот 2000 он
12. Л.Насанцэнгэл “Оюуны хомсдол” УБ хот 2008 он
13. Н.Орёл Л, Насанцэнгэл “Сэтгэц судлал” УБ хот 2009 он
14. Н.Орёл “Сэтгэцэд нөлөөт эмүүд” УБ хот 2011 он
15. Л.Отгонбаяр “ Тархины цахилгаан бичлэг” УБ хот 2012 он
16. Н.Оюунчимэг, Л.Насанцэнгэл, О.Ганчулуун, Л.Эрдэнэбаяр “Сэтгэцэд нөлөөт эмийн эмчилгээ эмийн бус эмчилгээний аргууд” УБ хот 2010 он

17. Г. Цагаанхүү "Мэдрэл судлал" УБ хот 2007, 2012 он
18. Л.Эрдэнэбаяр, Д.Болдцэрэн "Сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийн ангилал, онош тавих заавар" УБ хот 1994 он
19. Л.Эрдэнэбаяр "Шүүхийн сэтгэц судлалын лекцүүд" УБхот 2009он
20. Л.Эрдэнэбаяр "Архинд донтох өвчин" УБ хот 2009 он
21. Л.Эрдэнэбаяр "Аддиктология" Томск 2010
22. Л.Эрдэнэбаяр "Сэтгэцийн эрүүл мэндийн судлалын нэр томьёоны тайлбар" УБхот 2010он
23. Л.Эрдэнэбаяр "Архидах хорт зуршлаас ангижрах загварчлал" УБхот 2010 он
24. Л.Эрдэнэбаяр"Наркологийн нэр томьёоны тайлбар" УБ хот 1996 он
25. Л.Эрдэнэбаяр"Мансуурал судлалын үндэс" УБхот 2001 он
26. Л.Эрдэнэбаяр"Мансуурах дон судлал" УБхот 2002 он
27. Л.Эрдэнэбаяр "Хүн амд үзүүлэх наркологийн тусламж" УБ хот 2005 он
28. Л.Эрдэнэбаяр"Донтох эмгэгийн эмчилгээ" УБхот 2006 он
29. Л.Эрдэнэбаяр "Донтох эмгэг судлал" УБ хот 2009 он
30. Л.Эрдэнэбаяр "Монгол хүний архинд донтох зуршлыг арилгах загварчлал" УБ хот 2012 он

***Сэтгэцийн эрүүл мэнд судлалаар анагаах ухааны докторын зэрэг хамгаалсан диссертацийн сэдвүүд:***

1. Шанжийн Доржжадамба "Даамжрах саа өвчний клиник, эмчилгээний онцлог" Москва 1964г
2. Цэрэн-Очирын Гүрдорж "Сэтгэлийн шалтгаант өвчний тархалт, клиникийн онцлог" Москва 1969г
3. Сандагийн Бямбасүрэн "Тархины судасны өвчнүүдийн тархалтын зарим асуудал, судасны шалтгаант солиорлуудын эмнэлзүйн явцыг харьцуулан судалсан нь" УБ хот 1973 он
4. Боовонгийн Чойдог "БНМАУ дахь өсвөр насны хүмүүсийн эпилепси өвчний тархалт, клиникийн онцлог" УБ хот 1978 он
5. Лувсандоржийн Эрдэнэбаяр "Монгол улс дахь архинд донтох өвчний клиник, тархалтын асуудал" Томск 1991г
6. Намдагийн Орёл "Сэтгэцийн зарим өвчний эхлэл үеийн сульдлын байдлуудыг эмгэг сэтгэл судлалын аргаар эрт ялган оношлох нь" УБ хот 1992 он
7. Дамдинсүрэнгийн Болдцэрэн "Эрэгтэй хүнд невроз үүсэхэд бэлгийн эмгэг болон бие хүний сэтгэлзүйн онцлог нөлөөлөх нь" УБ хот 1992 он
8. Лхагвасүрэнгийн Насанцэнгэл "Сургуулийн насны хүүхдийн дундах оюуны хомсдол өвчний тархалт, эмнэлзүй-удамзүйн зарим онцлог" УБ хот 1999 он
9. Наранбатын Дэмидмаа"Архинд донтох өвчинтэй эцэг эх бүхий хүүхдүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдал" УБ хот 2000 он
10. З.Хишигсүрэн "Шизофренийн эмнэлзүйн асуудалд" УБ хот 2007 он
11. Д.Гантөмөр "Архинд донтсон өвчтөний эмгэг сэтгэлзүйн илрэлүүд" УБ хот 2012
12. Батхүрэлийн Жаргал "Биеших эмгэгийн зарим асуудалд", УБ хот. 2015 он
13. Төмөр-Очирын Ганцэцэг "Сэтгэл цочирдлын хоёр туйлт эмгэгийн эмнэлзүйн асуудалд", УБ хот. 2016 он
14. Даваасүрэнгийн Оюунсүрэн "Амиа хорлох үзэгдэл, нөлөөлөх хүчин зүйлс", УБ хот, 2018 он
15. Ванчиндоржийн Баярмаа "Өсвөр насныхны сэтгэл хөдлөл, зан үйлийн судалгаа", УБ хот, 2019 он
16. Бүддоржийн Пүрэвжаргал "Архины шалтгаант дэмийрэл бүхий үгүйлэх хам шинжийн эмнэлзүйн судалгаа", УБ хот, 2021 он

***Сэтгэцийн эрүүл мэнд судлалаар анагаахын шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан диссертацийн сэдвүүд:***


1. Цэрэн-Очирын Гүрдорж "Эпидемиология, клиника и профилактика невротический реакций и неврозов и условиях МНР" Софияг1989
2. Лувсандоржийн Эрдэнэбаяр "Эпидемиология, клиника и научно-организационные основы профилактики алкоголизма в Монголии" Томск 1997г


***Бусад бүтээлүүд:***


1. С.Бямбасүрэн, Н.Орёл ба бусад. "Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхим үүсэн байгуулагдсаны 60 жилийн ойн онол-практикийн ба хурал" УБ хот 2007 он
2. С.Бямбасүрэн, Л.Эрдэнэбаяр нарын "Сэтгэцийн эрүүл мэндийн албаны тулгамдсан асуудлууд" (онол, практикийн хурлын хураангуй) УБ хот 2009 он
3. Ш.Доржжадамба, Л.Эрдэнэбаяр, Б.Аюушжав "Монголын сэтгэц-наркологийн алба 70 жил" УБ хот 1999 он
4. Ш.Доржжадамба, С.Бямбасүрэн, Н.Орёл, Л.Эрдэнэбаяр "Хорьдугаар зууны Монгол дахь сэтгэцийн эмгэгийн тархалтын байдал" УБ хот 1996 он
5. Ш.Доржжадамба, Л.Эрдэнэбаяр, Б.Аюушжав "Монголын сэтгэц наркологийн албаны 70 жил" УБ хот 1999 он
6. Л.Эрдэнэбаяр "Хорьдугаар зууны үеийн Монгол улс дахь Сэтгэцийн эмгэгийн тархалтын байдал" УБ хот 1996 он
7. Л.Эрдэнэбаяр "Сэтгэцийн эрүүл мэндийн албаны 80 жилийн түүхэн замнал" УБ хот 2009 он


***Хууль тогтоомж, баримт бичиг:***


1. "Сэтгэцийн эрүүл мэндийн тухай" Монгол улсын хууль 2000 он
2. "Сэтгэцийн эрүүл мэндийн тухай" Монгол улсын шинэчлэн найруулсан хууль 2013 он
3. "Сэтгэцийн эрүүл мэндийн тухай" Монгол улсын үндэсний хоёр дахь хөтөлбөр 2009 он
4. "Эрүүл мэндийн тухай" Монгол улсын хууль 2010 он
5. "Зонхилон тохиолдох өвчин, эмгэгийн оношлогоо эмчилгээний удирдамж" УБ хот 2005 он
6. "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ" УБ хот 2006 он
7. "Эмчийн ёс зүй" УБ хот 2012 он